



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/196

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
эрүүл мэнд, нийгмийн хамгааллын
салбар комиссыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” 173 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Б/34 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Дүүргийн 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилго бүхий дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, салбар комиссын гишүүдтэй гэрээ байгуулж, хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулахыг Салбар комисс (С.Мөнхзаяа)-т, салбар комиссын шийдвэрийг үндэслэн холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Эрүүл мэндийн төв (З.Балдандугар)-д, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (Г.Батбаяр)-т, Боловсролын хэлтэс (Л.Жаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссыг шинэчлэн байгуулах тухай” Дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/111 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (С.Мөнхзаяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Д.ЖАРГАЛСҮРЭН

Баянгол дүүргийн Засаг даргын
2023 оны 4 дугаар сарын 26 өдрийн
4/136 дугаар захирамжийн хавсралт



САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар комиссын дарга:	С.Мөнхзаяа	(Баянгол дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга)
Нарийн бичиг:	Э.Солонго	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд:		
Боловсролын ажилтан	Г.Баялагмаа	(Баянгол дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн боловсролын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
Нийгмийн ажилтан	Г.Гэрэлтуяа	(Баянгол дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн)
Хүүхдийн эмч	Л.Хулан	(Эрүүл мэндийн төвийн Хүүхэд өсвөр үеийн эмч)
Мэдрэлийн эмч	Б.Амаржаргал	(Эрүүл мэндийн төвийн Хүүхдийн мэдрэлийн эмч)
Төрийн бус байгууллагын Төлөөлөл	Г.Цэен	(“Энэрлийн түүчээ” ТББ-ын төлөөлөл)